



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/922

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Олон нийтийн оролцоот сургууль-Хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөрийн 6.1.9 дэх заалтын дагуу эцэг эх, олон нийтийн бүтээлч үйл ажиллагаа өрөгжүүлж байгаа сайн туршлагыг нийтийн хүртээл болгох эмхэтгэл хэвлүүлэх зардалд 984000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээний зардалд 984000 төгрөг / есөн зуун наян дөрвөн мянга/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.9 дэх “Олон нийтийн оролцоот сургууль-Хүний хөгжлийн төв” хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ